



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/178

Хэрлэн сум

Бог малын хээлтүүлэгчийг  
үзлэг ангилалтад хамруулж,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 16 дугаар зүйлийн 16.8.6, 16.9.2, 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны “Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг үнэ батлах тухай” А-68 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2021 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдааны “аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад бүрэн хамруулан ашиг шимийг тогтоож, зэмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг технологид хугацаанд зохион байгуулахад 32,000,000 (гучин хоёр сая төгрөг) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад хамруулахад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Үзлэг ангилалтын ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2022 оны 6 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



БОГ МАЛЫН ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙГ ҮЗЛЭГ АНГИЛАЛТАД  
ХАМРУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Сумын нэр	Нийт хээлтүүлэгчийн тоо	Хээлтүүлэгч		Нэгж үнэ	Ангилалтанд шаардагдах мөнгөн дүн (мян.төг)
			Хуц	Ухна		
1	Галшар	2861	1795	1066	1500	2145750
2	Баянхутаг	2782	1901	881	1500	4173000
3	Баянмөнх	1458	947	511	1500	2187000
4	Дархан	2014	1269	745	1500	1136000
5	Дэлгэрхаан	1327	749	578	1500	1990500
6	Жаргалтхаан	1007	627	380	1500	1510500
7	Цэнхэрмандал	1093	671	422	1500	1639500
8	Өмнөдэлгэр	3186	1866	1320	1500	2389500
9	Батширээт	271	174	97	1500	406500
10	Биндэр	1159	658	501	1500	1738500
11	Баян-Адарга	1154	710	444	1500	1731000
12	Дадал	115	73	42	1500	86250
13	Норовлин	1192	752	440	1500	1788000
14	Батноров	2424	1569	855	1500	1818000
15	Баян-Овоо	1110	750	360	1500	1665000
16	Мөрөн	1246	751	495	1500	1869000
17	Хэрлэн	3894	2285	1609	1500	2920500
18	Бор-Өндөр	537	292	245	1500	805500
	Аймгийн дүн	28830	17839	10991		32000000